



Бурхан сэргэлтийг өгдөг! Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан сэргэлтийг өгдөг!

Attribute: God Revives!

Тодорхойлолт: Амь амьдралыг өгөгч, ахин хөгжил цэцэглэлтийг өгдөг, шинээр эрч хүч өгөгч Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Дуулал 71:19-21** Учир нь аугаа зүйлсийг хийсэн Бурхан, Таны зөвт байдал тэнгэрт хүрсэн. Бурхан, хэн Тантай адил вэ? Надад олон зовлон шаналанг үзүүлсэн Та Намайг дахин сэргээж, Газрын гүнээс дахин татан гаргана. Та агуу байдлыг минь улам өсгөж, Намайг тайвшруулахаар эргэнэ.
- **Дуулал 138:7** Хэдийгээр зовлон шаналангийн дунд би явах болсон ч Та намайг сэргээнэ. Дайснуудын минь уур хилэнгийн өмнөөс Та мутраа сунгах бөгөөд баруун мутар тань намайг аварна.
- **Исаиа 57:15** Ариун хэмээх нэртэй, мөнх амьдрагч, Өндөрт өргөмжлөгдсөн Нэгэн ийн айлдав. “Сүнсэндээ дарууг нь сэргээхийн тулд, Зүрхнээсээ гэмшсэнийг нь сэргээхийн тулд Сүнсэндээ даруутай нь, гэмшсэн нэгэнтэй нь Би өндөрт, ариун газарт оршдог.
- **Езекиел 37:1-6** ЭЗЭНий мутар миний дээр ирж, намайг ЭЗЭНий Сүнсээр авч яваад, хөндийн дунд буулгав. Тэнд дүүрэн яс байлаа. Тэр намайг тэдний дээгүүр эргэн тойрон явууллаа. Харагтун, тэр хөндийн гадарга дээр үлэмж их яс байсан агаад тэдгээр нь бүр хувхайрсан байв. Тэр надад— Хүний хүү! Энэ яснууд амилах уу? хэмээсэнд би—Эзэн БУРХАН, Та мэднэ гэв. Тэгээд Тэр надад— Эдгээр ясан дээр эш үзүүлж, тэдгээрт “Хувхай яснууд аа, ЭЗЭНий үгийг сонсогтун” гэж хэл. Эзэн БУРХАН эдгээр ясанд ингэж айлдаж байна. “Харагтун, та нар амилахын тулд Би та нар уруу амьсгалыг оруулна. Би та нарт шөрмөс өгч, дээр чинь мах ургуулж, та нарыг арьсаар бүрхэж, та нарт амьсгал оруулах бөгөөд та нар амилж та нар Намайг ЭЗЭН гэдгийг мэдэх болно” хэмээв.
- **Тит 3:4-7** Харин бидний Аврагч Бурханы энэрэл болон хүний төлөөх хайр нь ил болоход Тэр биднийг зөвт байдлын дотор хийсэн үйлсээр минь бус, харин өршөөлийнхөө дагуу шинэтгэлийн угаал ба Ариун Сүнсний шинэчлэлээр аварсан юм. Тэрээр Ариун Сүнсийг бидэн дээр Аврагч Есүс Христээр маань дамжуулан арвин асгав. Түүний нигүүлслээр зөвтөгдсөнөөр бид мөнх амийн найдварын дагуу өвлөгчид болох юм.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.* 1 Тесалоник 5:18

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Дуулал 119:37-38

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр)-ыг Хуурмаг хоосон зүйлсрүү бус харин зөвхөн Таны төлөвлөгөөрүү эргүүлж өгөөч.

Өөрийн замд түүний сэтгэлийг сэргээж өгөөч. Таны амлалтууд Танд итгэдэг, Таныг эмээн хүндэтгэдэг нэгний төлөө байдаг гэдгийг (Хүүхдийн нэр)-д бататгаач.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____ ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу , Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____-ыг Хуурмаг хоосон зүйлсрүү бус харин зөвхөн Таны төлөвлөгөөрүү эргүүлж өгөөч. Өөрийн замд түүний сэтгэлийг сэргээж өгөөч. Таны амлалтууд Танд итгэдэг, Таныг эмээн хүндэтгэдэг нэгний төлөө байдаг гэдгийг _____-д бататгаач. *Дуулал 119:37-38*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!